



231

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2009 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 444

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн, Засгийн газрын 2003 оны 79 дүгээр тогтоолоор баталсан "Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Зөвшөөрөл, бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай тушаалыг хэрэгжүүлэхэд мөрдөх заавар"-ыг хавсралтаар баталж, энэ оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэ зааврыг хяналтын улсын байцаагч нарт судлуулах, тайлбарлан таниулах, хилийн боомт, орон нутгийн Албадад хүргэх, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хяналтын хэлтсийн дарга Н.Баянмөнх, Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга П.Ихзаяа нарт үүрэг болгосугай.

3. Энэ заавар батлагдсантай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны даргын 2007 оны 237, 300 дугаар тушаал, 2008 оны 274 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Д.МӨРӨН

0000391



232

Гадаадын иргэн, харьяатын асуудал
эрхлэх газрын даргын 2009 оны
144 дугаар тушаалын хавсралт

**ГАДААДЫН ИРГЭНИЙГ МОНГОЛ УЛСААС АЛБАДАН ГАРГАХ,
ОРОХЫГ ҮЛ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ ТУШААЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
МӨРДӨХ ЗААВАР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү зааврын зорилго нь Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний "Монгол Улсаас албадан гаргах тухай", Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын /цаашид газрын гэх/ даргын "Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх тухай" тушаалыг тус тус хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр. Монгол Улсаас албадан гаргах, тус улсад орохыг үл зөвшөөрөх тухай тушаалын төслийг бэлтгэх

2.1 Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2001 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны дүрэм", Засгийн газрын 2003 оны 79 дүгээр тогтоолоор баталсан "Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах журам"-ыг тус тус үндэслэн хилийн боомт, орон нутаг дахь Албадын дарга, зөвшөөрөл, бүртгэлийн хяналтын улсын байцаагч нар /цаашид хяналтын улсын байцаагч гэх/ Хяналтын хэлтсийн даргын нэр дээр албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх гадаадын иргэний талаар үндэслэл бүхий танилцуулгыг энэ зааврын 2.7 дахь хэсэгт заасны дагуу бүрдүүлэн, улсын хил нэвтрүүлэхээс өмнө нэн даруй ирүүлэх буюу харилцаа холбоогоор тодорхой мэдэгдэнэ.

2.2 Танилцуулгад дараах зүйлийг тодорхой тусгасан байна. Үүнд:

- Зөрчил гаргасан гадаадын иргэний талаарх үндсэн мэдээлэл /иргэний харьяалал, овог, нэр, төрсөн огноо, хүйс, паспорт буюу түүнийг орлох баримт бичгийн дугаар, тус улсад нэвтэрсэн визийн ангилал, хугацаа, зориулалт, ялгаа, визийн сунгалт/
- Зөрчлийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл
- Захиргааны зөрчлийн зүйлчлэл /Хуулийн зүйл, хэсэг, торгуулийн хэмжээг дэлгэрэнгүй бичнэ/
- Хууль, тогтоомжийн дагуу тус улсад орох эрхийг нь хязгаарлах хугацаа

2.3 Хяналтын хэлтсийн дарга нь албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай танилцуулгыг хүлээн авч, холбогдох хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж, албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай тушаалын төслийг бэлтгэн Газрын даргад танилцуулан шийдвэр гаргуулах, холбогдох саналыг Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнд хүргүүлэх ажлыг гардан зохион байгуулна.

2.4 Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнд "Монгол Улсаас албадан гаргах" тухай тушаалын төслийг саналын хамт бэлтгэн хүргүүлэхдээ албадан гаргагдаж буй гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийн нүүрэн хэсэг, зөрчил бүхий хэсгийг хуулбарлан хамт явуулна.

2.5 Хууль зүй, дотоод хэргийн Сайдын тушаалаар албадан гаргаж буй гадаадын иргэний паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн "OBSERVATION" гэсэн хуудасны төв хэсгийн дээрээс 1 см зайд **"МОНГОЛ УЛСААС АЛБАДАН ГАРГАВ"** дардасыг хар өнгийн тосон бэхээр, түүний доод хэсэгт **"ОРОХЫГ ХОРИГЛОСОН ХУГАЦААНЫ ДАРДАС"**-ыг хөх өнгийн тосон бэхээр тус тус хамтад нь дарах бөгөөд хоёр дардасын хоорондох зай 1 см байна.

2.6 Газрын даргын тушаалаар орохыг үл зөвшөөрсөн гадаадын иргэний паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн "OBSERVATION" гэсэн хуудасны төв хэсгийн дээрээс 1 см зайд зөвхөн **"ОРОХЫГ ХОРИГЛОСОН ХУГАЦААНЫ ДАРДАС"**-ыг хөх өнгийн тосон бэхээр дарна.

2.7 Албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай тушаалд гадаадын иргэний паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн нүүрэн хэсэг, зөрчил бүхий хэсэг, тус улсаас албадан гаргасан болон орохыг үл зөвшөөрсөн хугацааг заасан дардас бүхий хэсэг, гарах визтэй хэсгийг тус тус хуулбарлан авч, хадгаламжийн нэгж болгон бүрдүүлнэ.

Гурав. Албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай
шийдвэрийг хэрэгжүүлэх

3.1 Албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай тушаалыг албадан гаргах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн хүлээн авмагц "Паспорт хяналтын нэгдсэн сүлжээ" мэдээллийн санд нэн даруй оруулна.

3.2 Албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан хэрэгжилтийн талаар тухайн шийдвэрийг гаргасан эрх бүхий албан тушаалтны нэр дээр илтгэх хуудсаар танилцуулна.

3.3 Албадан гаргах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай шийдвэрийн хуулбарыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хил хамгаалах байгууллагад тус тус албан ёсоор хүргүүлнэ.

3.4 Албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай тушаалын дагуу гадаадын иргэнийг албадан гаргах, орох эрхгүйгээр гаргаж байгаа тохиолдолд Хяналтын хэлтсийн хяналтын улсын байцаагч цагдаагийн байгууллагатай, хилийн боомт, орон нутаг дахь Албадын дарга, хяналтын улсын байцаагч хил хамгаалах байгууллагатай хамтран улсын хилээр зохих журмын дагуу гаргахад биечлэн оролцож, хяналт тавьж ажиллана.

3.5 Албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай тушаалын дагуу улсын хилээр гаргаж байгаа гадаадын иргэнийг хилийн боомт, орон нутаг дахь Албадын дарга,

хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нь хэрхэн хил нэвтрүүлсэн тухай тодорхойлолт бичиж, Буянт-Ухаа боомт албадан гаргасан даруйд нь, Замын-Үүд, Сүхбаатар, Алтанбулаг боомтууд ажлын нэг хоногт багтаан, бусад боомтууд ажлын тав хоногт багтаан Хяналтын хэлтэст ирүүлнэ.

3.6 Албадан гаргах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн нь хилийн боомт, орон нутаг дахь Албадын дарга нарт "Монгол Улсаас албадан гаргах тухай" болон "Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх тухай" тушаалын хуулбарыг хүргүүлж, хүлээн авч, хяналт тавьж ажиллаж байгаа тухай хилийн боомт, орон нутаг дахь Албадын дарга нараас ирүүлсэн илтгэх хуудсыг даргын туслахад шилжүүлэн нэгдсэн бүртгэлд оруулна.

3.7 "Монгол Улсаас албадан гаргах тухай" болон "Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх тухай" тушаалаар тус улсад нэвтрэх эрхээ тодорхой хугацаагаар хасуулсан гадаадын иргэн паспорт, түүнийг орлох бичиг баримтаа солин хил нэвтрэхийг завдсан тохиолдолд холбогдох тушаалд заасан хугацаагаар нь зохих дардсыг дахин дарж, ирсэн тээврийн хэрэгслээр нь буцаах бөгөөд энэ журамд заасны дагуу паспорт, түүнтэй адилтгах бусад баримт бичгийг хуулбарлан авч, архивлан хадгална.

3.8 Хилийн боомт, орон нутаг дахь Албадын дарга, хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нь Газрын даргын нэр дээр албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай тушаалаар арга хэмжээ авагдсан гадаадын иргэн дахин хил нэвтрэхийг завдсан тухай илтгэх хуудсыг хил нэвтрэхийг завдсан паспорт, түүний орлох бичиг баримтын хуулбарын хамт ирүүлнэ.

3.9 Албадан гаргах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн нь албадан гаргах, орохыг үл зөвшөөрөх тухай тушаалаар арга хэмжээ авагдсан хугацаанд тус улсын хилээр нэвтрэхийг завдсан гадаадын иргэний мэдээллийг "Паспорт хяналтын нэгдсэн сүлжээ" мэдээллийн санд нэн даруй оруулна.